

ЯР ШАРХНЫ ӨВЧИНД ХЭРЭГЛЭДЭГ ЭМИЙН ТУС ЭРДМИЙГ ЭРТНИЙ АНАГААХ УХААНЫ СУРВАЛЖААС ТОГТООХ НЬ

Баасансүрэн Оюун-Эрдэнэ¹, Баттогтох Гэрэлмаа^{2*},
 Дашжамц Шагдарсүрэн¹, Шарав Болд^{1,2}

¹Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

²Уламжлалт Анагаах Ухааны Сургууль, “Ач” Анагаах ухааны их сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

*цахим хаяг: gerelmaa.b@ach.edu.mn

IDENTIFYING THE DRUG ACTION FOR ULCERS AND INJURIES FROM ANCIENT MEDICAL MANUSCRIPT

Oyun-Erdene Baasansuren¹, Gerelmaa Battogtokh^{2*},
 Shagdarsuren Dashjamts¹, Bold Sharav^{1,2}

¹Department of Traditional Medicine, Mongolian University of Pharmaceutical Sciences, Ulaanbaatar, Mongolia

²Department of Traditional Medicine, Ach Medical University, Ulaanbaatar, Mongolia

*email: gerelmaa.b@ach.edu.mn

Abstract

Introduction: The National Library of Mongolia was established in 1921 based largely on the 8th Khalkha Jebtsundamba Library. In studying the tradition of collecting and preserving books in Mongolia, the subject can be divided into three categories:

1. Family collection
2. Palace/ Royal collections
3. Monastery collections.

From the collection mentioned above, we selected a work belonging to the royal collections, specifically one transferred from the VIII Khalkha Jebtsundamba's Library to the National Library. This book, “The drug actions that are useful for any kind of ulcer, swelling, and injuries,” is a rare and valuable item of medical cultural heritage, existing in a single known copy. Therefore, this work was selected for incorporation into the research cycle.

To identify the formulas, forms of medicines, methods of use, actions, and to abstain from diet methods in the book “The drug actions that are useful for any kind of ulcer, swelling, and injuries.”

Methods: We employed methods such as the study of original texts and sources, analytic- synthetic method.

Conclusion: The book includes methods for using 27 various medicines to treat 26 types of diseases related to the lesions. Some medicines can be used externally in addition to oral administration, and 90% of all medicines are in the form of powders and granules for external application.

Keywords: drug action, injuries, medical cultural heritage, Mongolian manuscript, traditional medicine, ulcers.

Үндэслэл

Монгол Улсын Үндэсний номын сангийн фондын үндсэн хэсэг нь Богдын номын сангийн суурин дээр бий болжээ. VIII Богдын номын санд монгол, төвөд, манж, хятад хэлээр бичсэн, монгол, төвөд, санскрит, манж, хятад хэлнээс орчуулсан олон боть судрууд байв. Үүнд, Буддын шашны мэдлэг ухааны цоморлог их таван ухаан: дуун ухаан, шалгадаг ухаан, урлах ухаан, тэжээхүй ухаан, дотоод ухаан, бага таван ухаан: зохист аялгуу, илт өгүүлэхүй, эвсүүлэн найруулах, дууриал бүжиг, одон зурхай болон түүх шастир, уран зохиол, цадиг намтар, хятадын анагаах ухааны эм судлал, хууль, хүн судлал зэрэг салбар бүрийн ном судрууд байсан тухай баримт тэмдэглэгдэн үлджээ¹.

Монголчуудын ном цуглуулж хадгалж ирсэн уламжлалыг судалж үзэхэд:

1. Гэрийн номын цуглуулга
2. Хаад, ноёдын орд харш дахь номын цуглуулга
3. Сүм хийдийн дэргэдэх номын цуглуулга гэж гурав хуваадаг.

Үүнээс гадна өөрийнх нь бичсэн ном судраас бүрдсэн мэдлэгийн их сан хөмрөгийг үлдээсэн мэргэд олон байсан. Энэхүү санг мөн сүмбүм буюу бүрэн зохиолын эмхэтгэл гэдэг. Сүмбүм бүхий мэргэдийн хамгийн ойрын жишээ бол Дамаагийн Минжүүр ёнзонгийн судар ном, бүтээлийн эмхэтгэл юм. Минжүүр ёнзонгийн бүтээл нийтдээ одоогийн байдлаар 15 боть байгаагаас 11 боть нь зохиол бүтээлийн эмхэтгэл, 3 боть нь ном сонссон тэмдэглэл, 1 боть нь Ганжуурын жүдрим буюу дамжлагын дараалал гэсэн хэсгээс бүрдэнэ. Түүний бүтээлийн га ботид гэхэд л өөрийн шүтсэн 53 багшийн товч цадиг, эрдэнийн эрхис тэргүүтэй 20 ном гэх мэт урьд нь бүрэн судлагдаагүй, зохиол бүтээл нь төдийлөн олонд танигдаагүй эрдэмтэн лам нарын товч намтар, бүтээлүүд нь гарчигтайгаа байгаа нь Монголын бурхны шашны номын мэргэдийн намтар, бүтээлийг тодруулахад ихээхэн ач холбогдолтой юм^{2,3,4}.

Бид дээрх цуглуулгын дотроос Хаад, ноёдын орд харш дахь номын цуглуулгад багтах бүтээл буюу тодруулж хэлбэл VIII Богдын номын сангаас Үндэсний номын санд шилжүүлэн авч хадгалж байгаа номыг судлахаар сонгон авлаа. Энэхүү

“Аливаа яр, хавдар гарсан, шалбарсан зэрэг өвчинд тустай эмийн тус эрдэм” нэрт ном нь ганц хувь хадгалагдаж буй үнэт ховор анагаах ухааны соёлын өв юм. Номын эмийн болон түүхий эдийн нэр томьёо нь манж, хятад хэлээр бичигдсэн. Харин эмийн тайлбар ба өвчний эмгэг жамын тайлбар нь монгол бичгээр бичигджээ. Иймд уг бүтээлийг судалгааны эргэлтэд оруулахаар сонгон авлаа.

Зорилго

“Аливаа яр, хавдар гарсан, шалбарсан зэрэг өвчинд тустай эмийн тус эрдэм” номд буй эмүүдийн тус эрдмийг тогтоох

Материал, арга зүй: “Аливаа яр, хавдар гарсан, шалбарсан зэрэг өвчинд тустай эмийн тус эрдэм” нэрт судар нь “Гүй лин жи хэмээх эм ба жич эр эм хүмүүний олон зүйлийн өвчинд тустай буюу аливаа яр хавдрын зэрэг өвчин, мөн олон зүйлийн өвчинд тустай эмүүдийн тус эрдэм ба лан жий сан, тай чан, гин дан хэмээх үрэл эмүүдийн тус эрдэмууд”⁵ хэмээх цогц олон судрын тав дахь судар юм. Уг судрын хэмжээ нь 33,5x17,2см, 30 нүүр, улаан сатин даавуун хавтастай, 4 цоолон үдэж нуруулдсан, шар муутуу цаасан дээр хичээнгүй бичгээр, хар бэхээр, бийрээр бичсэн гар бичмэл энэхүү бүтээлийг судлахдаа бид эх бичиг, сурвалж судлалын арга, анализ синтезийн аргуудыг ашиглалаа.

Судалгааны үр дүн:

“Аливаа яр, хавдар гарсан, шалбарсан зэрэг өвчинд тустай эмийн тус эрдэм” нэрт номд төрөл бүрийн яр, шарх, тууралт, хавдарт хэрэглэх эмийн үйлдлийн талаар бичиж тэмдэглэсэн байна.

Table 1. Some drug actions

No	Drug name	Actions	Usage
1	化毒湯 Huà dú tāng	Боом хавдранд	3 аяга усанд чанаж 1%-аар даруулж бүлээн ууна.
2	奪命丹 Duó mìng dān	Энэ үрэл хамаг биед түгсэн яр ба бас нэг хоёр ч яранд	Хар архиар зуурч түрхнэ.
3	三黃抱腦丸 Sān huáng bào nǎo wán	Аливаа унасан, дэлгэрсэн шарх, мэс, модоор жанчигдсан шарх бас могой хатгасан, хорт хорхойд зуугдсан, эр хүн хэтэрхий хүчилж юн олсон, эхнэр хүн хөнгөжсөний хойно биеийн хир хураагдсан эсвээс муу цус дээш дэвэрч элдэв муу өвчин болж мэдээ үгүй болвоос гагц амандаа өчүүхэн амьсгал байваас эдгэж чадмой.	Хүнд болвоос нэг, хоёр үрэл хөнгөн болвоос нэг үрэл үнэргүй архиар даруул. Хэрвээ шарх олж өдөр удаад өвчин маш хүнд болбоос дараа дараагаар хэдэн удаа уулгаваас бүхэл биенийн юн цусыг арилгаад шинэ цусыг төрүүлмой.
4	梅花點吉丹 Méihuā diǎn jí dān	Элдэв зүйлийн зэрлэг яр, мухар чихиганы яр, олон зүйлийн муу хорт хавдар шинэ гарсанд ууваас даруй сарнимой.	Уух бүр нэг мөхлөг урьдаар усыг нэг үмх уугаад үрлийг хэлний дээр тавьж ам минчүүрсэн цагт үлдсэн усаар даруулж уугаад хөлс гарваас сайн.

Хүснэгт 1-д үзүүлсэнчлэн тус номд буй эмүүдийн тус эрдэм нь өөр хоорондоо харилцан адилгүй бичигдсэн байна. Нийт 27 нэрийн эм байгаа бөгөөд зарим нь ижил нэртэй ч өнгөөрөө ялгаатай нь бичигдсэн. Бид үүнээс засах өвчин, эмийн хэлбэр, хэрэглэх арга зэргийг түүвэрлэв.

Засах өвчин:

- Боом хавдар, битүү хавдар (өвдөг хавдах, сүвээнд гарах, эм хүний хөхөнд гарах), олон зүйлийн муу хорт хавдар, хөхний хавдар, шинэ гарсан хүрэн өнгөтэй хавдар
- Хамаг биед түгсэн яр эсвэл ганц нэг яр, мухар чихиганы яр, хоолойны дотор яр, гарын алганы яр, гүвдрүү яр, бага хүүхдийн аливаа яр, нурууны яр, хөлийн шалбархай яр, булчирхай яр
- Унасан дэлгэгдсэн шарх, ир мэс модоор занчигдсан шарх
- Галзуу нохой ноцсон, могой хатгасан, хорт хорхойд зуулгасан

- Эр хүн хэтэрхий хүчилж юн (хят. 殞 – yǔn мон. гэм, сүйрэл, үхэл хагацал) олсон
- Эхнэр хүн хөнгөжсөн хойно биеийн хир хураагдсан эсвээс муу цус дээш дэвэрч элдэв муу өвчин болсон.
- Чийгийн хороор бие эвэршээн үл зогсох
- Нэргүй хавдаж халуун оргих
- Хошногоны шамбарам
- Хамуу
- Салхинд цохигдож чоно хөрвөс туурсан зэрэг 26 төрлийн өвчнүүд дурдагдсаныг эмхэтгэв.

Уламжлалт анагаах ухааны өвчин болж биед орох ёсны ойлголтын дагуу аливаа хавдсан, шархадсан өвчнийг “Арьс маханд гүйж, цул саванд нэвтрэн, тийнхүү судас хаагдан бөглөгдөж, арга бэлэг хоёр амьсгал тойрон нэвтэрч чадахгүй...” хавдар болно гэж тодорхойлсон байна. _

Дээрх өвчнүүдийн үед хэрэглэх эмүүд нь энэхүү номд мөхлөг, үрэл, талхалсан нунтаг гэсэн эмийн хэлбэрүүдтэй байгаа бөгөөд зарим эмүүдийг

уухаас гадна давхар гадуур хэрэглэх боломжтой бөгөөд нийт эмийн 90% нь гадуур түрхэж хэрэглэх нунтаг, мөхлөг хэлбэрийн эмүүд байна. Хэрэглэх аргын хувьд өвчний хөнгөн, хүндээс хамааруулж утах, уулгах, түрхэх, шавших зэргээр зааварласан болохыг түүвэрлэв. Үүнд:

- Хулсаар үлээх,
- Чанаж бүлээнээр уух, архиар даруулж уулгах, хэлэн дээр тавьж аманд минчүүрэхийн цагт усаар даруулж уух, арвайн шөлөөр уух, эхнэр хүний сарын буулт ховор болбоос гүргэмийн усаар буцалгаж уух
- Хар архиар зуурч түрхэх, хүйтэн усаар зуурч түрхэх, тосоор зуурч түрхэх, исгэлэн (цуу тэргүүтэн) юманд зуурч түрхэх, хужиртай хар цайнд зуурч түрхэх, шавших зэрэг аргууд болно.

Түүнчлэн “эмийг хумиулан халуун архиар даруулж уулгаад, хүчээр бөөлжүүлж, дахин нэг хоёр хундага халуун архиар ууж эмийг хүчийг туслан хөлс гарваас сайн болмуй” гэсэн арга нь бөөлжүүлэг засалтай хавсарснаараа онцлог байна. Мөн шархны эмчилгээ хийж байх үед “шүүс бага гарвал түрхлэгийг түрхээд цаасаар дар, их гарвал шүүсийг арчаад дахин түрх” хэмээн зааварчилгааг дэлгэрэнгүй гаргажээ. Цаашлаад “Хуурай яранд хар цайгаар зуурч, хавдарт исгэлэн цуу тэргүүтнээр зуурч, халуун юм, галд түлэгдсэн, шалбархай зэрэгт тахианы өндөгний цагаанд хольж түрхэх, түрхэхдээ тахианы өдөөр түрхвээс эрхэм сайн” гэж яр, хавдар, шарханд тохируулан эмийг хэрэглэх эмчилгээний туршлагат аргуудаас тусгаснаараа давуу талтай байна.

Эмчилгээний үед Чин Шү Фан хэмээх эм нь “Аливаа муу яр гарч өвчин хүнд бөгөөс олон лав өвдөхгүй, заримдаа ундарч минчүүрэн⁶, заримдаа бөхөлзөж огшиход энэ эмийг ууваас өсөж товойхгүй нь даруй товойж, өвдөхгүй нь даруй өвдөн, бүтэгдэхүй нь тархаж, нэгэнт бүтсэн нь идээлэн лавламуу. Үүгээр эмийн амьдруулах гавьяа буй амуй” гэсэн үйлдэл гаргадаг нь халууныг боловсруулж, нуугдсаныг ил гаргах үйлдэл үзүүлдэг болохыг үзүүлж байна.

Энэхүү бүтээлд яр, шарх, хавдрын эмчилгээний эмийн үйлдлийг нь муу цусыг арилгаж шинэ цусыг төрүүлэх, муу цэрийг арилган уг амьсгалыг сахих, хорыг тайлж, яс шөрмөсийг

залгуулж, халуун хорыг боловсруулах, нойтон халууныг хөхөх, нойтон шар усыг анагаах, идээ цусыг хураах, хавдсаныг хураах гэж тодорхойлсныг тогтоов.

Эмүүдийг хэрэглэж, эмчилгээг хийж байх үеийн цээрлэлт нь эм уусан хойно түүхий идээ, архи, хүйтэн ус, иссэн идээ, тос, нясуун халуун чанартыг эрхэмлэн цээрлэх байна.

“Аливаа яр, хавдар гарсан, шалбарсан зэрэг өвчинд тустай эмийн тус эрдэм” номд морь, луус, илжгийн зэрэг аливаа малын шарханд хэрэглэх эмийг оруулсан байгаагаараа онцлогтой байна.

Хэлцэмж

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-ийн Шархыг засах үест яр, шархны өвчнийг өгүүлэхдээ шалтгаан нөхцөл, мөн чанар, орших орон, ялгал, шинж, засах арга, бурууг дарах, сүүлийг таслах⁷ гэсэн 8 зүйлээр үзүүлсэн байна. Үүнээс засах аргад (1) хавдрыг дарах, (2) эргэснийг арилгах: тус бүрд эргэснийг, гэмтсэнийг, сарнисныг, шургасныг, дэвэрснийг, яс идэгдсэнийг засах, (3) махыг төрүүлэх, (4) зохих, зохихгүй идээ явдлыг ерөнхийд нь уялдуулах, (5) язгуурын үүднээс тус бүр засах⁸ гэсэн 5 арга. Эндээс харвал аливаа яр, шархны өвчний үед хамгийн эхлээд хавдрыг дарах эмчилгээ хийх зарчимтай байна. Өөрөөр хэлбэл “Анагаах ухааны дөрвөн үндэс”-т яр гарсан, шарх олсон үед хавдар нь өвчний шинж байгаа бол харьцуулж үзэхэд “Аливаа яр, хавдар гарсан, шалбарсан зэрэг өвчинд тустай эмийн тус эрдэм” номд яр болон шархнаас тусад нь өвчин байдлаар тусган эмчилгээний аргадаа оруулан бичжээ.

Дүгнэлт

Тус номд яр, шарх, хавдрын бүлэгт хамаарах 26 төрлийн өвчний үед хэрэглэх 27 зүйлийн эмийн хэрэглэх аргуудыг багтаажээ. Зарим эмүүдийг уухаас гадна давхар гадуур хэрэглэх боломжтой бөгөөд нийт эмийн 90% нь гадуур түрхэж хэрэглэх нунтаг, мөхлөг хэлбэрийн эмүүд байна.

Ном зүй

1. Тунгалаг Б. Наймдугаар Богд Жавзандамба хутагтын номын сангийн гар бичмэл номын номзүйн судалгаа. Улаанбаатар, 2011, х. 31
2. Болд Ш., Жавхлан Б. Хүннүгээс XXI зууны Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш бариач нарын цадиг, бүтээлийн ойллого. УБ, 2016, х. 261-269.
3. Болд Ш, бусад. Монгол туургатны анагаах ухааны алдарт эмч, маарамба, мэргэдийн намтар, бүтээлийн тойм (НТӨ VII зууны өмнөөс XIX зууны сүүлч хүртэл), УБ, 1999. х.25.
4. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2011. х. 49.
5. Гүй лин жи хэмээх эм ба жич эр эм хүмүүний олон зүйлийн өвчинд тустай буюу аливаа яр хавдрын зэрэг өвчин, мөн олон зүйлийн өвчинд тустай эмүүдийн паян ба лан жий сан, тай чан, гин дан хэмээх үрэл эмүүдийн паянууд. х.37-52.
6. Норжин Ц., Мөрөн М. Монгол хэлний толь. ӨМӨЗО-ы Ардын хэвлэлийн хороо, 1997.
7. Энхсүвд Б., Мөнхням Т., Чоймаа Ш. Анагаах ухааны дөрвөн үндэс. Уламжлалт анагаах ухааны 108 боть: Боть 6. Болд Ш., редактор. УБ, 2020. х.306-378.
8. Ютиг Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн үндэс. Шин Вэй Лин, орч. ӨМӨЗО-ы Үндэсний хэвлэлийн хороо, 1991. х. 1131-1433.